



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 02 сарын 04 өдөр

Дугаар Б/17

Чингис хот

Д.Сайнболдод буцалтгүй
тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, аймгийн Засаг даргын Тамгын газрын “Дотоод журам”-ын 7.12-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газарт тасралтгүй 28 жил, үүнээс Цэргийн штабын даргаар 22 жил ажилласан байгууллагын өндөр настан Д.Сайнболд нь Бүгд Найрамдах Солонгос Улсын нуруу нугасны эмнэлэгт 21,0 сая төгрөгний үнэлгээтэй дурангийн хагалгаа хийлгэхээр болсон тул эмчилгээний зардалд зориулж байгууллагын дотоод журамд заасны дагуу 300000 /гурван зуун мянга/ төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Буцалтгүй тусламжийн 300000 /гурван зуун мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэг удаагийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /Г.Ариунхүү/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

231030070